Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

Салбарын хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын
хяналтын улсын ахлах байцаагч Нороврэнцэнгийн Одончимэгийн
2024 оны гүйцэтгэлийн тайлан

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн дуусах хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрэх түвшин(биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Салбарын хяналт шалгалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно”** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 1.1.** ТХШТХ-ийн 9.2.1 Хүнсний үйлдвэр, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, батлуулна. | Батлагдсан хяналтын хуудас-15 | ЭМС-ын 2023 оны А/78 дугаар тушаал | Шинэчлэн боловсруулсан тушаал | Хүнсний эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлийн нийт 15 хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/76 дугаар тушаалаар батлуулсан. | 2024.01 2024.02 | 100% |
| 2 | **Арга хэмжээ 1.2.** ТХШТХ-ийн 9.2.1 Тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдах болон согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх ажлын байранд урьдчилсан хяналт хийх хяналтын хуудас шинээр боловсруулж, батлуулна . | Шинэ хяналтын хуудас-3 | - | 100% | -Тамхи худалдах ажлын байранд эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг үнэлэх 10.13.2 кодтой хяналтын хуудсыг шинээр боловсруулан Эрүүл мэндийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/76 дугаар тушаалаар батлуулсан.<br>- ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газартай хамтран 8.10.4 кодтой “Согтууруулах ундаагаар үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг шалгах хяналтын хуудас”, 8.11.2 кодтой “Согтууруулах ундаа худалдах худалдааны газрын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас” шинээр боловсруулж, ЭМС, ХХААХҮС-ын 2024.04.22-ны өдрийн А/261/А190 дугаартай хамтарсан тушаалаар батлуулсан. | 2024.01 2024.04 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | "Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5021-1:2024" стандарт шинэчилэгдэн батлагдсантай холбогдуулан 8.11.2 кодтой хяналтын хуудсыг дахин шинэчилж, боловсруулан 2 сайдын хамтарсан 2024.07.08-ны өдрийн А/497, А/317 дугаартай тушаалаар батлуулсан. | | |
| **Зорилт 2. " Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлнэ"** | | | | | | | |
| 3 | **Арга хэмжээ 2.1.**<br>ХБАБХТХ-ийн 6.4, 18.1, ЗГ-ын 2023 оны 420 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 12, ЭМС-ын 2023 оны А/484 дугаар тушаал<br>Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн хүнсний үйлдвэр, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад төлөвлөгөөт хяналт шалгалт зохион байгуулна. | Объектын хамралтын хувь | 68.9% | 80% | **Объектын хамралт 86.9 хувь.**<br>**Их эрсдэлтэй объектын эзлэх хувь 7.7 хувь.**<br>**Хууль тогтоомжийн хэрэгжилт 76.4 хувь.**<br>Хяналт шалгалтад хамрагдахаар зарлагдсан нийт 560 объектоос 487 буюу 86.96 хувийг хамруулсан гүйцэтгэлтэй, өмнөх онтой харьцуулахад 17.16 хувиар нэмэгдсэн.<br>487 объект 7 хяналтын хуудасны үнэлгээгээр их эрсдэлтэй 55 (14.5%), дунд эрсдэлтэй 235 (49.1%), бага эрсдэлтэй 197(41.2%), эрсдэл үүсэх магадлалын дундаж 34.9 хувь, хууль тогтоомжийн хэрэгжилт 66.0 хувьтай үнэлэгдэж, холбогдох арга хэмжээ авч, 276 объектод гүйцэтгэлийн хяналт хийж ажилласаны дүнд 37(7.7%) нь их эрсдэлтэй, 217(45.5%) нь дунд эрсдэлтэй, 233(47.8%) нь бага эрсдэлтэй, эрсдэл үүсэх магадлалын дундаж 24.7%, хууль тогтоомжийн хэрэгжилт **76.4% зорилтотод түвшинд хүрсэн.**<br>Шалгалтаар 6342 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 3244 заалттай 304 албан шаардлагаар үүрэг өгч, 56 аж ахуйн нэгж, иргэнд 54.250.000 төгрөгийн шийтгэвэр ногдуулж, барагдуулан, зөрчлийн үр дагаврыг арилгуулахаар 55 эрх бүхий албан тушаалтны албан даалгавраар үүрэг өгч хэрэгжилтийг 100% хангуулсан. Ілэрсэн зөрчлийн арилгуулалт 67.64%(нийслэлд 75.2%, орон нутагт 63.6%) байна. Хяналт шалгалтын явцад ундны усны 99, үйлдвэрийн бохир ус 4, хоолны 22, хүнсний бүтээгдэхүүний 74 дээж, эрүүл зүйн арчдас | 2024.01<br>2024.11 | 100% |
| | | Эрсдэлийн түвшин | Их -10.3% | Их эрсдэлтэй объектын эзлэх хувийг 3 хүртэл хувиар бууруулна | | | |
| | | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь | | | | | |
| | | | 68.3% | 74% | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шинжилгээг 781 цэгээс авч, лабораторийн шинжилгээнд хамруулан, шинжилгээний дүнг үндэслэн 41 улсын байцаагчийн дүгнэлт үйлдсэн байна. | | |
| | Дэд арга хэмжээ 2.1.1. Төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамж боловсруулж батлуулна. | Батлагдсан удирдамж | - | Удирдамж батлуулсан байна. | Хүнсний чиглэлийн 560 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай удирдамж боловсруулан, Салбарын хяналтын газрын даргаар батлуулж, 2024.02.19-ний өдрийн 10-00/22 дугаарт бүртгүүлэн, аймаг, нийсэлийн ЭМГ-т хүргүүлсэн. | 2024.01<br>2024.02 | 100% |
| | Дэд арга хэмжээ 2.1.2. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг ахлаж, чиглэлийн улсын байцаагчдыг мэргэжил арга зүйгээр ханган, эхний хагас жилд хийсэн хяналт шалгалтын мэдээг нэгтгэсэн байна. | Эхний хагас жилийн хяналт шалгалтын явцын мэдээ | - | Хяналт шалгалтын явцын мэдээ | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтын явцын тоон мэдээг 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэгтгэж, газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланд тусгав. Эхний хагас жилийн байдлаар 323 объектод хяналт шалгалт хийхэд биелэлт 57.6 хувьтай(аймгийн түвшинд 35.5%,нийслэлд 64.4%), амрагдсан 323 объектыг хяналтын хуудсаар үнэлэхэд их эрсдэлтэй 46, дунд эрсдэлтэй 177, бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Хагас жилийн байдлаар дүнг нэгтгэж газрын болон яамны төлөвлөгөөнд тусгасан. | 2024.05<br>2024.06 | 100% |
| | Дэд арга хэмжээ 2.1.3. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын Хяналт шалгалтын нэгжээс ирүүлсэн хяналт шалгалтын дүнг нэгтгэж, дүгнэлт цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт газрын удирдлагад танилцуулна. | Нэгдсэн танилцуулга | - | Нэгдсэн танилцуулга | Удирдамжийн хүрээнд Салбарын хяналтын газар,нийслэл, 19 аймгийн Эрүүл мэндийн газраас 7 хяналтын хуудсаар 487 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн хяналтын хуудсыг нэгтгэж, хяналт шалгалтын нэгдсэн дүнгийн танилцуулгыг бичиж, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний саналын хамт 2024.11.21-ний өдөр газрын даргад танилцуулах хуудсаар танилцуулсан. | 2024.11 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Арга хэмжээ 2.1.4.<br>ХБАБХТХ-ийн 6.4, 18.1, ЗГ-ын 2023 оны 420 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 12, ЭМС-ын 2023 оны А/484 дугаар тушаал<br>Архангай аймгийн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн 6 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийнэ. | Объектын хамралтын хувь<br>Эрсдэлийн үүсэх магадлалын хувь<br>Хууль сахин мөрдөлтийн хувь | -<br>-<br>- | 80%<br>2%-иар бууруулна<br>60% | Архангай аймагт хяналт шалгалтад хамруулах 6 объектоос 5(83%) хамрагдсан.Тансаг Трейд ХХК нь худалдааны төвийн барилгын өргөтгөл хийж байгаатай холбогдуулан үйл ажиллагаа түр хугацаагаар зогссон байна. Хамрагдсан объектын 2(40%) нь “бага эрсдэлтэй”, 3(60%) нь “их эрсдэлтэй”, эрсдэлийн дундаж 50.42 хувь, хууль, тогтоомжийн хэрэгжилтийн дундаж 48.7 хувь байна. Шалгалтын явцад нийт 54 зөрчил, дутагдал илэрч, Гость Трейд ХХК, Миний дэлгүүр ХХК-ийн Архангай аймаг дахь 306 дугаар салбарт эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангуулахаар 29 заалттай 2 албан шаардлагыг хүргүүлж, албан шаардлагын биелэлтийг ирүүлсэн.<br>Миний дэлгүүр ХХК-ийн Архангай аймаг дахь 306 дугаар салбарт илэрсэн зөрчлийг тус аймгийн Цагдаагийн газарт 2024.09.26-ны өдрийн 9/3941 дугаартай албан бичиг хүргүүлж, Зөрчлийн 2412000744 дугаартай хэрэг нээж, шалгагдаж байна. СХЗГ-т Архангай аймгийн Баталгаажуулалтын зөвлөл нь тус MNS 5021-1:202” стандартын шаардлагыг бүрэн хангаагүй худалдааны газарт “Супермаркет” ангилалаар “Тохирлын гэрчилгээ” олгож, гэрчилгээн дээр Миний дэлгүүр ХХК-ийн нэрийг Миний сүлжээ ХХК гэж ташаа бичсэн асуудлыг шалгуулахаар Салбарын хяналтын газрын даргын 2024. 10.10-ны өдрийн 9/3942 дугаартай албан бичгээр хүргүүлж, шийдвэрлүүлж ажилласан. | 2024.09 | 100% |
| 5 | **Арга хэмжээ 2.2.**<br>ХБАБХТХ-ийн 18.1<br>Нийтийг хамарсан баяр ёслол, цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээнд хийгдсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулна. | Зөрчил арилгуулалтын хувь | 64% | 66% | **Илэрсэн зөрчил арилгуулалт 67.4 хувьтай.**<br>ЭМЯ, ХХААХҮЯ-ны Салбарын Улсын ерөнхий байцаагч нарын хамтран баталсан 2024 оны 08-00-02/03 дугаар удирдамжийн хүрээнд хяналт шалгалтад хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч 2532 объектод хамтарсан хяналт шалгалт хийж, 8427 зөрчил дутагдлыг илрүүлэн, 123 аж ахуйн нэгж, иргэнд илэрсэн дутагдлыг арилгуулахаар 1065 заалттай албан шаардлагыг хугацаатай хүргүүлж, 923 заалт буюу 86.6%-ыг | 2024.02<br>2024.12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хангуулж, Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийг зөрчсөн 21 аж ахуйн нэгж, иргэнд 30 сая 400.0 мянган төгрөгийн шийтгэврийг хялбаршуулсан журмаар ногдуулж, 100% барагдуулан, зөрчлийн үр дагаврыг арилгуулахаар эрх бүхий албан тушаалтны 21 албан даалгавар өгч биелэлтийг хангуулсан. Хуульд заасныг үндэслэн шошгын зөрчилтэй 7 нэр төрлийн 535 ширхэг, 71 кг, 1019.7 мянган төгрөгийн үнэ бүхий бүтээгдэхүүнийг буцаан татан авалт хийлгэж, хадгалалтын хугацаа хэтэрсэн 195л, 119 кг, 5218 ширхэг, 28 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг албадлагын журмаар хураан авч, холбогдох орон тооны бус устгалын комисст улсын байцаагчийн 134 актаар шилжүүлсэн.<br>**Нийт 4 удаагийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын 5680-г буюу 67.4** хувийг арилгуулж зорилтод шалгуурт хүрсэн ч цаг үеийн шаардлагаар богино хугацаанд хамтарсан хяналт шалгалт хийхэд ЭМЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын нэгжүүдэд эрүүл ахуй, халдвар хамгааллын улсын байцаагч дутагдалтай, хяналт шалгалт хийхэд шатахуун, унааны хүрэлцээгүй байдал нь тулгамдсан | | |
| | | | | | асуудал болоод байна.<br>Улсын хэмжээнд хүнсний асуудал хариуцсан эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчийн тоо, хүнсний чанар, стандартын хяналтын байцаагчийн тоотой харьцуулахад 2-3 дахин бага байна. | | |
| 6 | **Арга хэмжээ 2.3.**<br>ХБАБХТХ-ийн 6.5<br>Мах, махан бүтээгдэхүүн, өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэгчдийн хүсэлтээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулна. | Шийдвэрлэлтийн хувь | 100% | 100% | **Хүсэлтийн шийдвэрлэлтийн 100 хувь.**<br>Аж ахуйн нэгж, иргэнээс өндөр эрсдэлтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэхэд дүгнэлт гаргуулах 37(нийслэлд 8, аймагт 29) хүсэлтийг хүлээн авч, хуульд заасан хугацааны дотор **100% шийдвэрлэсэн.**<br>Ирүүлсэн хүсэлтээс 7 объект өндөр эрсдэлтэй хүнсний үйлдвэрлэл биш байх тул хуульд заасан үндэслэлийн тайлбар бүхий албан бичиг хүргүүлж, 30 үйлдвэрийг 10.11.1 кодтой "Мах, | 2024.02<br>2024.12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийн эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудас", 10.11.2 кодтой "Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэхэд урьдчилсан хяналт хийх эрүүл ахуйн хяналтын хуудас"-аар үнэлхэд 3(10.0%) нь "их эрсдэлтэй", 2(6.6%) "дунд эрсдэлтэй", 25(83.3%) нь "бага эрсдэлтэй" үнэлэгдэж бага эрсдэлтэй үнэлэгдсэн 25 үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, иргэнд Засгийн газрын 2022 оны 224 дүгээр тогтоолоор баталсан "Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт", Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт MNTR 2:2011-ийн эрүүл ахуйн шаардлагыг хангаж байгаа тухай улсын байцаагчийн 25 дүгнэлт үйлдэж, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалтын биелэлтийг хангуулж ажиллалаа. | | |
| | Дэд арга хэмжээ 2.3.1 Мах, махан бүтээгдэхүүн, өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэгчдийн хүсэлтээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийг боловсруулан, батлуулах | Батлагдсан удирдамж | - | Удирдамж батлуулсан байна. | Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолоор батлагдсан Салбарын хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу "Мах, махан бүтээгдэхүүн, өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэгчдэд үйл ажиллагаа явуулахаас өмнө урьдчилсан хяналт шалгалт хийх" удирдамжийг ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газартай хамтран боловсруулж, ЭМЯ, ХХААХҮЯ-ны Салбарын Улсын ерөнхий байцаагч нараар батлуулж, 2024.02.05-ны өдрийн 10-00/14 дугаартай удирдамжийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн. | 2024.01<br>2024.02 | 100% |
| | Дэд арга хэмжээ 2.3.2 Батлагдсан удирдамжийн дагуу аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын хяналт шалгалтын нэгжээс ирүүлсэн хяналт шалгалтын дүнгийн танилцуулгыг нэгтгэн, дүгнэлт, цаашид авч | Нэгдсэн танилцуулга | - | Нэгдсэн танилцуулгыг газрын удирдлагад танилцуулсан байна. | Нэгдсэн дүнгийн танилцуулга бичиж, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний саналын хамт 2024.11.27-ны өдөр газрын даргад танилцуулах хуудсаар танилцуулсан. | 2024.11. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт газрын даргад танилцуулна. | | | | | | |
| 7 | **Арга хэмжээ 2.4.**<br>ТХТХ-ийн 6.1<br>Тамхи, тамхин бүтээгдэхүүний хорт бодис, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийж дүгнэлт гаргах хяналт шалгалтыг зохион байгуулна. | Шийдвэрлэлийн хувь | 100% | 100% | **Хүсэлтийн шийдвэрлэлтийн 100 хувь.**<br>Тамхи, тамхин бүтээгдэхүүний хорт бодисын агууламж, чанар, аюулгүй байдалд дүгнэлт гаргуулах хүсэлт ирүүлсэн 16 аж ахуйн нэгжийн давхардсан тоогоор 102 нэр төрлийн тамхи, тамхин бүтээгдэхүүнд Засгийн газрын 2013 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журамд заасны дагуу дагалдах бичиг баримтад эрсдэлийн үнэлгээ хийж, бүтээгдэхүүнээс дээж авч, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид физик, хими, хор судлал, хөгц мөөгөнцөр, цацрагийн бохирдол тодорхойлох шинжилгээнд хамруулан, сорилтын дүнд үндэслэн стандарт, техникийн шаардлагад нийцсэн тухай улсын ахлах байцаагчийн 28 дүгнэлт үйлдэж, хүсэлтийг 100 хувь шийдвэрлэн, Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.6, 6.7 дахь заалтуудын хэрэгжилтийг хангуулж ажиллалаа.<br>Хяналт, шалгалтын явцад 1 аж ахуйн нэгжид 3 заалттай хугацаатай албан шаардлагыг хүргүүлэн, гүйцэтгэлийн хяналтаар хэрэгжилтийг 100 хувь хангуулсан. | 2024.01<br>2024.11 | 100% |
| | Дэд арга хэмжээ 2.4.1<br>Тамхи, тамхин бүтээгдэхүүний хорт бодис, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийж дүгнэлт гаргах тухай удирдамж боловсруулан, батлуулна. | Батлагдсан удирдамж | - | Удирдамж батлуулсан байна. | "Тамхи, тамхин бүтээгдэхүүний хорт бодисын агууламж, чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай" удирдамж боловсруулан, 2024.02.06-ны өдрийн 10-00/32 дугаартай удирдамжийг Салбарын хяналтын газрын даргаар батлуулсан. | 2024.01<br>2024.02 | 100% |
| | Дэд арга хэмжээ 2.4.2<br>Батлагдсан удирдамжийн хүрээнд аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын Хяналт шалгалтын нэгжээс | Нэгдсэн танилцуулга | - | Нэгдсэн танилцуулгыг газрын даргад | Нэгдсэн дүнгийн танилцуулга бичиж, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний саналын хамт 2024.11.27-ны өдөр газрын даргад танилцуулах хуудсаар танилцуулсан. | 2024.10<br>2024.11 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ирүүлсэн хяналт шалгалтын дүнг нэгтгэж, дүгнэлт цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт газрын удирдлагад танилцуулна. | | | танилцуулсан байна. | | | |
| 8 | **Арга хэмжээ 2.5.** ТТХТХ-ийн 20.2 Гадаад болон төр засгийн тэргүүн, тусгай хамгаалалтад байхаар заагдсан албан тушаалтны ажлын айлчлалын үеийн хоол хүнсний аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалтыг зохион байгуулна. | Шийдвэрлэлтийн хувь | 100% | 100% | **Хүсэлтийн шийдвэрлэлтийн 100 хувь.** Төрийн тусгай хамгаалалтын газраас ирүүлсэн 25 албан бичгийг үндэслэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх заалтын хүрээнд хөтөлбөрт тусгагдсан нэр бүхий 144 (хүнсний чиглэлийн 123, бусад 21) объектод урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, ирүүлсэн албан хүсэлтийг 100% шийдвэрлэж ажиллалаа. Шалгалтаар эрүүл ахуйн нөхцөл шаардлага хангаагүй 167 зөрчил, дутагдал илрүүлж, үйл ажиллагааны хөтөлбөрийн товлосон хугацаанаас өмнө арилгуулах арга хэмжээг яаралтай авсаны дүнд 131 буюу 78.4 хувийг богино хугацаанд арилгуулан, хөрөнгө, хугацаа шаардагдах дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 18 заалттай 2 албан шаардлага, 36 заалт бүхий 4 зөвлөмж өгч хэрэгжилтийг нь хангуулсан. Марриот ХХК-ийн Асем ресторанд илэрсэн зөрчилтэй холбогдуулан Төрийн тусгай хамгаалалтын газрын холбогдох албан тушаалтанд Төрийн өндөр дээд хэмжээний айлчлалын арга хэмжээг цуцлах саналыг албан бичгээр шуурхай хүргүүлж, тухайн объектыг өөрчлүүлж болзошгүй эрсдэлээс сэргийлж ажиллалаа. | 2024.01 2024.12 | 100% |
| | Дэд арга хэмжээ 2.5.1. Гадаад болон төр засгийн тэргүүн, тусгай хамгаалалтад байхаар заагдсан албан тушаалтны ажлын айлчлалын үеийн хоол хүнсний аюулгүй байдалд урьдчилан | Батлагдсан удирдамж | - | Удирдамж батлуулсан байна. | Гадаад болон төр засгийн тэргүүн, тусгай хамгаалалтад байхаар заагдсан албан тушаалтны ажлын айлчлалын үеийн хоол хүнсний аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамж боловсруулан, Салбарын хяналтын газрын даргаар батлуулан, 2024.01.18-ны өдрийн 10-00/07 дугаартай | 2024.01 2024.12 | 100% % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамж боловсруулан, батлуулна. | | | | удирдамж боловсруулан, батлуулж аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн. | | |
| | Дэд арга хэмжээ 2.5.2. Батлагдсан удирдамжийн хүрээнд аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын Хяналт шалгалтын нэгжээс ирүүлсэн хяналт шалгалтын дүнг нэгтгэж, дүгнэлт цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт газрын удирдлагад танилцуулна. | Танилцуулга | - | Нэгдсэн танилцуулга бичсэн | Нэгдсэн дүнгийн танилцуулга бичиж, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний саналын хамт 2024.11.27-ны өдөр газрын даргад танилцуулах хуудсаар танилцуулсан. | 2024.11 | 100% |
| 9 | **Арга хэмжээ 2.6.**<br>ЭАТХ-ийн 5.3<br>Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, зураг төсөл зохиох, ашиглалтад оруулахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт шалгалт хийнэ. | Шийдвэрлэлийн хувь | 100% | 100% | **Хүсэлтийн шийдвэрлэлт 100 хувь.**<br>Тайлант хугацаанд барилга байгууламжийн зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийлгэх 24 хүсэлтийг хүлээн авч, 22 зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийж, улсын ахлах байцаагчийн 22 дүгнэлт гаргаж, зураг төслийг баталгаажуулсан.<br>Зураг төсөл, баримт бичгийн бүрдэл дутуу, барилгын норм, дүрмийн эрүүл ахуйн шаардлага хангаагүй 2 аж ахуйн нэгжийн хүсэлтэд албан тоотоор хариу өгч ажиллалаа. | 2024.01<br>2024.12 | 100% |
| 10 | **Арга хэмжээ 2.7.**<br>ЭАТХ-ийн 8.2<br>Түүхий эд, бараа бүтээгдэхүүн, бодис, бэлдмэлийг экспортлох, импортлох хүсэлтийн дагуу эрүүл ахуйн дүгнэлт гаргана. | Шийдвэрлэлийн хувь | 100% | 100% | Алтан заан трейд ХХК-ийн албан хүсэлтийн дагуу Австрали Улсаас импортлон хүнсний худалдааны сүлжээнд нийлүүлж буй “Biostime” нэрийн 6 төрлийн нялх, балчир хүүхдийн сүүн тэжээлээс дээж авч, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид шинжлүүлэн улсын ахлах байцаагчийн “Шинжлэгдэхүүний тухай” 1 дүгнэлт гаргаж хүргүүлэв. | 2024.01<br>2024.12 | 100% |
| 11 | **Арга хэмжээ 2.8.**<br>ТХШТХ $5^2$.1<br>Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу | Шийдвэрлэлтийн хувь | 100% | 100% | **Шийдвэрлэлт 100 хувь.**<br>1.Байгууллага, иргэдээс ирүүлсэн 4 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн 3 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж, 1 зөрчлийг хялбаршуулсанаар, 2 зөрчилд зөрчлийн хэрэг үүсгэн 3 аж ахуйн нэгжид 9 сая төгрөгийн торгох шийтгэл ногдуулж, 100% барагдуулан, зөрчлийн | 2024.01<br>2024.12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөт бус шалгалт хийнэ. | | | | үр дагаврыг 3 эрх бүхий албан тушаалтны албан даалгавар хүргүүлж арилгуулсан.<br>-Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас ирүүлсэн албан бичгийн хүрээнд иргэний гомдолд хяналт хийсэн НЭМГ-ын хяналт шалгалтын дүнг татан хянаж, гомдол гаргасан иргэний гомдлыг нэг мөр шийдвэрлэн албан бичгээр хариуг хүргүүлсэн.<br>**2.** ЭМС-ын 2024.06.03-ны өдрийн А/258 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Улаанбаатар хотноо 2024 оны 08 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулагдах Дэлхийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалтын үеэр зохион байгуулах газар, зочид төлөөлөгчдийн байрлах зочид буудал, хоол, хүнсний аюулгүй байдал, шаардлагатай тохиолдолд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх бэлэн байдлыг зохион байгуулалтаар хангах, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг томилуулж, хоёрдугаар хавсралтаар ажлын төлөвлөгөөг батлуулсан.<br>Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төрийн ёслол, үйлчилгээний салбар хорооны даргын томилсоноор “Үндэсний их баяр наадмын Төрийн ёслол, үйлчилгээний салбар хорооны бүрэлдэхүүний ажлын хэсэг”, Соёлын яамын Сайдын 2024 оны А/146 дугаартай тушаалаар “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийг зохион байгуулалтаар хангах чиг үүрэгт бүхий дэд ажлын хэсэгт тус тус томилогдон ажилласан. | | |
| 12 | **Арга хэмжээ 2.9.**<br>Нялх, балчир хүүхдийн хүнсний худалдаанд урьдчилсан сэргийлэх шалгалтыг зохион байгуулна. | Арилгуулсан зөрчлийн хувь | - | 70% | **Арилгуулсан зөрчлийн хувь 74.4 хувьтай.**<br>Нийслэлийн 7 дүүрэг, 16 аймагт үйл ажиллагаа явуулж буй 289 аж ахуйн нэгж, 62 иргэний 351 хүнсний худалдааны худалдааны объектыг шалгалтад хамруулхад, давхардсан тоогоор 203 нэр, төрлийн нялх, балчир хүүхдийн сүүн тэжээл, нэмэгдэл тэжээл худалдаалагдаж, түүний 99.4 хувь нь импортын бүтээгдэхүүн эзэлж байна. Худалдааны газруудад нийт 349 зөрчил, | 2024.03<br>2024.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дутагдал илрүүлэн, 59 заалттай 27 улсын байцаагчийн албан шаардлага, 76 заалттай улсын байцаагчийн 23 зөвлөмжийг хүргүүлэн, гүйцэтгэлийн хяналт тавьж, **зөрчил, дутагдлын 74.4%-г арилгуулаад байна**. Шалгалтаар шошгын мэдээллийн шаардлага хангахгүй 3 нэр төрлийн 115 ширхэг 357800 төгрөгийн нэмэгдэл хоолыг буцаан татан авахуулсан. Хамрагдсан объектуудын түвшинд Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн Хоёрдугаар бүлэг /Зориулалтын бүтээгдэхүүний найрлага, сав баглаа боодол, шошгод тавих шаардлага, хориглох зүйл/ 80.72 хувийн хэрэгжилттэй, энэ нь өмнөх оны хяналт, шалгалтын дүнгээс 2.82 хувиар (77.9%) нэмэгдсэн.<br>Худалдаалагдаж байгаа зориулалтын бүтээгдэхүүний 94 хувь нь импортын бүтээгдэхүүн эзлэж байх тул хуульд заасан чанар, аюулгүй байдлын баталгаажилт, шошгод тавигдах ерөнхий болон тусгай шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг гаалийн хяналтаар нэвтрүүлэхгүй байхад анхаарч, Эрүүл ахуйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтыг хэрэгжүүлхэд импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний эрсдэлийг тогтоох, үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулах шаардлагатай байна. | | |
| 13 | **Арга хэмжээ 2.10.**<br>Тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдаалах зөвшөөрөл шинээр авах, зөвшөөрлийн хугацаа сунгуулах аж ахуйн нэгжийн хүсэлтээр ажлын байранд урьдчилан сэргийлэх шалгалтыг хийнэ. | Шийдвэрлэлтийн хувь | - | 100% | **Хүсэлтийн шийдвэрлэлт 100 хувь.**<br>Тайлант хугацаанд 583 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг хүлээн авч, Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14 дэх заалтыг хангаагүй байршилд үйл ажиллагаа явуулж буй 46 худалдааны газрын хүсэлтэд дүгнэлт гаргахаас татгалзсан хариуг албан бичгээр хүргүүлэн, 537 худалдааны газарт 10.13.2 кодтой хяналтын хуудасны дагуу хяналт шалгалт хийж, “бага эрсдэлтэй” үнэлэгдсэн 458 худалдааны газарт 454 “Үйл ажиллагааны тухай” улсын байцаагчийн дүгнэлт үйлдэж, хүсэлтийг 100 хувь шийдвэрлэн ажиллалаа. | 2024.02<br>2024.12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хяналт шалгалтаар давхардсан тоогоор 495 зөрчил, дутагдлыг илрүүлэн, 493 заалттай 61 хугацаатай албан шаардлага, 21 улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлж, хууль бусаар тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдан борлуулж байсан 1 аж ахуйн нэгжид илэрсэн зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж 3 сая төгрөгийн торгох шийтгэл ногдуулж, хадгалах хугацаа дууссан 5 нэр төрлийн 25 ширхэг 99.2 мянган төгрөгийн тамхийг хурааж, устгуулахаар, зөвшөөрөлгүй худалдан борлуулж байсан 79 нэр төрлийн 437 ширхэг 1583.9 мянган төгрөгийн тамхи, тамхин бүтээгдэхүүнийг хурааж, улсын орлого болгуулахаартус тус аймгийн Засаг даргын дэргэдэх "Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан хөрөнгө эд зүйл хэрэгслийг үнэлэх, худалдан борлуулах, устгах талаар шийдвэр гаргах хэрэгжилтэд хяналт тавих орон тооны бус зөвлөл"-д шилжүүлж, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн дотор байршилтай зайд улсын байцаагчийн дүгнэлтгүйгээр тамхи худалдаалах зөвшөөрөл олгосон 3 үйл ажилагааны зөвшөөрлийг цуцлуулах саналыг сумын Засаг даргад албан бичгээр хүргүүлж ажилласан байна. | | |
| 14 | **Арга хэмжээ 2.11.** Согтууруулах ундаа худалдаалах түүгээр үйлчлэх зөвшөөрөл шинээр авах, зөвшөөрлийн хугацаа сунгуулах аж ахуйн нэгжийн хүсэлтээр ажлын байранд урьдчилан сэргийлэх шалгалт хийнэ. | Шийдвэрлэлтийн хувь | - | 100% | **Хүсэлтийн шийдвэрлэлт 100 хувь.** ЭМЯ, ХХААХҮЯ-ны Салбарын Улсын ерөнхий байцаагчийн хамтран баталсан 08-00-02/15 дугаартай удирдамжийн дагуу Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн $15^1$.1.3, $15^2$.1.3 дахь заалтыг үндэслэн улсын байцаагчийн дүгнэлт гаргуулах аж ахуйн нэгжийн 2230 хүсэлтийг хүлээн авч, 10 газрын хүсэлтийг холбогд<br>ох хуульд заасан үндэслэл, тайлбараар буцааж, 2220 объектод 2 хяналтын хуудсаар шалгалт хийхэд 98(4.4%) нь "их эрсдэлтэй", 342(15.4%) нь "дунд эрсдэлтэй", 1780(80.1%) нь "бага | 2024.03<br>2024.12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эрсдэлтэй” үнэлэгдэж, гүйцэтгэлийн хяналтын дүнд бага эрсдэлтэй объектын тоо хүнсний худалдааны газарт 76, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газар 51-ээр нэмэгдэж, бага эрсдэлтэй үнэлэгдсэн 1907 аж ахуйн нэгжид хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан тухай улсын байцаагчийн дүгнэлт үйлдсэн. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар 57 аж ахуйн нэгжид 514 заалттай хугацаатай албан шаардлага хүргүүлж, удирдамжийн хугацаанд гүйцэтгэлийг хяналт хийснээр 52 албан шаардлагын 371 заалтыг буюу 72.1 хувийг хангуулан , Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийг үндэслэн 4 аж ахуйн нэгжид 10000.0 сая төгрөгийн торгуулийг хялбаршуулсан журмаар ногдуулж, 10 нэр төрлийн 147 ширхэг 956.0 мянган төгрөгийн хэрэглэж дуусах хугацаа хэтэрсэн шар айргыг хураан, холбогдох орон тооны бус зөвлөлд устгуулахаар шилжүүлэн ажилласан. | | |
| 15 | **Арга хэмжээ 2.12.** Сургууль орчмын худалдааны цэгт урьдчилан сэргийлэх шалгалт хийнэ. | Арилгуулсан зөрчлийн хувь | - | 60% | **Арилгуулсан зөрчил 66.3 хувьтай.** Хяналт шалгалтад сургууль орчим 150 метр дотор байршилтай 306(238 аж ахуйн нэгж, 68иргэн)газрыг түүвэрлэн сонгож, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 370 дугаар тушаалаар батлагдсан “Сургууль орчимд хүүхдэд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүний жагсаалт”-д орсон хүнсний бүтээгдэхүүн худалдаалж буй эсэх, худалдан борлуулж буй бүтээгдэхүүний гарал үүсэл, баталгаажилт, ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл, шаардлага хангаж буй байдалд хяналт шалгалт хийж, 476 зөрчил, дутагдал илрүүлж, 316 буюу **66.3 хувийг** арилгуулсан.<br>Илэрсэн дутагдлыг арилгуулахаар 41 хуулийн этгээд, иргэнд 150 заалттай албан шаардлага хүргүүлж, гүйцэтгэлийн хяналт шалгалтаар 74%(111)-ийг хангуулж, эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг хангаагүй Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасныг зөрчсөн 9 аж ахуйн нэгж, | 2024.04<br>2024.11 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | иргэнд 17500.0 мянган төгрөгийн торгох шийтгэл ногдуулж, 100 хувь барагдуулан, зөрчлийн үр дагаврыг арилгуулахаар эрх бүхий албан тушаалтны 63 албан даалгавар хүргүүлж, биелэлтийг 100 хувь хангуулсан. ЭМС-ын 2021.06.15-ны өдрийн А/370 дугаартай тушаалын хавсралт "Сургууль орчимд хүүхдэд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүний жагсаалт"-д заасан хүнсний бүтээгдэхүүнийг хүүхдэд худалдаалсан үйлдэл эс үйлдэхүй нь Зөрчлийн тухай хуулийн шийтгэл оногдуулахаар заагдаагүй тул "зөрчил" гэж тооцох хариуцлагын санкц, хөшүүрэггүй, жагсаалт дахь хүнсний бүтээгдэхүүнийг бусад насны хүмүүст худалдаалж болох тул худалдааны зааланд хүүхдэд худалдаалсан эсэхийг камераар нь шүүж тогтооход Цагдаагийн байгууллагаас тодорхойлолт авах асуудал тулгардаг. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт нь "Энэ хууль нь ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа болон дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй (цаашид "сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ" гэх) холбоотой харилцаанд үйлчилнэ." гэж заасан. Гэтэл сургуулийн эдэлбэр газрын гадна талд өөрийн эзэмшилд хүнсний худалдааны үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд, иргэнд тус хууль, түүнийг даган гарсан эрх зүйн акт үйлчлэх эсэх талаар худалдаа эрхлэгч нарын зүгээс эсэргүүцэл тайлбар хийж, хяналт шалгалтыг явуулахад хүндрэлтэй асуудал тулгарч байна. | | |
| 16 | ХХААХҮЯ-ны Салбарын Улсын Ерөнхий байцаа гчийн 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 08-00-01/001/01 дугаартай "Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг | - | Албан шаардлагын хэрэгжилтийн хувь | 65% | ХААХҮЯ-ны Салбарын хяналтын газрын даргын баталсан "Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрүүдэд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" 08-00-03/23 тоот удирдамжийн хүрээнд аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Мал эмнэлгийн газар, Хүнс, хөдөө аж | 2024.12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хангуулах, хүнсний аюулгүй байдалд тавих хяналт шалгалтыг эрчимжүүлэх тухай" албан даалгаврын хүрээнд мах боловсруулах үйлдвэрүүдэд гүйцэтгэлийн хамтарсан хяналт шалгалт хийнэ. | | | | ахуйн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 8.1.3, 8.1.4 кодтой хяналтын хуудасны дагуу Засгийн газрын 2022 оны 224 дүгээр тогтоолоор батлагдсан "Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт"-ын хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэсэн байна.<br>Хяналт шалгалтад хамрагдвал зохих 102 аж ахуй нэгж хамрагдахаас 66 аж ахуй нэгж буюу 65 хувь нь хамрагдаж, хяналт шалгалтын явцад үйл ажиллагаа явуулаагүй зогссон 36 үйлдвэр байна.<br>Мал төхөөрөх үйлдвэрлэлийг шалгах 8.1.3 кодтой хяналтын хуудсаар нийт 60 үйлдвэрийн 25 үйлдвэр буюу 41.6% нь бага эрсдэлтэй, 20 үйлдвэр буюу 33.3% дунд, 12 үйлдвэр буюу 20% их эрсдэлтэй , Мах боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагааг шалгах 8.1.4 кодтой хяналтын хуудсаар нийт 6 үйлдвэрийн 3 үйлдвэр буюу 50% бага, 1 үйлдвэр буюу 16.6% дунд, 2 үйлдвэр буюу 33.3% нь их эрсдэлтэй үнэлэгдсэн.<br>Шалгалтаар 39 аж ахуй нэгжид давхардсан тоогоор нийт 2049 зөрчлийг илрүүлэн, 1241 заалт бүхий улсын байцаагчийн хамтарсан 40 албан шаардлагыг хүргүүлж, 3 аж ахуйн нэгж, 1 иргэнд 14 сая 500 мянган төгрөгийн торгууль ногдуулсан байна. Гүйцэтгэлийн хяналтаар 17 обьект бага, 6 объект дунд буюу эрсдэл буурч, **албан шаардлагын хэрэгжилт 72% байна.** Бага болон дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 31 аж ахуйн нэгжид үйл ажиллагааны тухай улсын байцаагчдын хамтарсан дүгнэлт үйлдсэн байна. | | |
| **Зорилт 3. "Улсын байцаагчдын чадавхийг сайжруулж, хяналт шалгалтын ил тод, тэгш байдлыг хангаж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ"** | | | | | | | |
| 17 | **Арга хэмжээ 3.1.**<br>ТХШТХ-ийн 9.1.3, 9.2.2 Хүнсний асуудал хариуцсан эрүүл ахуй, халдвар | Сургалтын тайлан | - | Сургалт, зохион байгуулсан байна. | Батлагдсан хөтөлбөрийн дагуу 2024.06.26-ны өдөр НЭМГ-ийн Эрүүл мэндийн хяналтын хэлтэс, АПУ ХК-ийн Чанарын хяналтын албатай хамтран тус үйлдвэрийн сургалтын танхим, | 2024.06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамгааллын хяналтын улсын байцаагч нарын “Ижил мэргэжилтэний уулзалт” сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулна. | | | | үйлдвэрлэлийн ажлын байранд “Ижил мэргэжилтэний уулзалт” сургалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа. Сургалт, хэлэлцүүлэгт НЭМГ-ын хүнсний асуудал хариуцсан эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын 19 улсын(ахлах) байцаагч, СХЗГ-ын ХАБҮЛЛ, Нийслэлийн Төв лабораторийн 8 менежер, шинжээч, аж ахуйн нэгжийн 11 эрүүл ахуйч эмч, нийт 38 мэргэжилтэн оролцож, хүнсний эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтаар илэрч буй зөрчил дутагдал, тулгамдсан асуудал, лабораторитой хяналт, хүнсний аюулгүй байдлын эрх зүйн орчныг сайжруулах талаар хэлэлцэж, гарсан шийдвэрийг холбогдох газруудад хүргүүлэхээр шийдвэрлэв. | | |
| 18 | **Арга хэмжээ 3.2.** Хүнсний үйлдвэр эрхлэгчдэд “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын үзүүлэлт, дотоодын хяналт” сургалт зохион байгуулна. | Сургалтын тайлан | - | Сургалт, зохион байгуулсан байна. | НЭМГ-тай хамтран 2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах газруудын удирдах ажилтан, ажиллагсад нарт салбарын 6 удаагийн сургалтыг НЭМГ-ын хурлын танхимд 6 (Баянгол дүүрэг, Хан-Уул дүүрэг, Сонгинохайрхан дүүрэг, Баянзүрх дүүрэг, Чингэлтэй дүүрэг, Сүхбаатар) дүүргийн нийт 110 хүнсний үйлдвэрлэл эрхлэгчид, хүнсний үйлдвэр, худалдаа, хоол үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг хамруулан “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын үзүүлэлт, дотоодын хяналт” , “Эрүүл ахуйн зохистой дадлыг хэрэгжүүлэх нь”, “Нийтийн эрүүл мэндэд оруулах таны хувь нэмэр болон хоол хүнсээр дамжих халдварт өвчний шалтгаан, урьдчилан сэргийлэх арга зам”, “Хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрын эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм”, “Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдахын ач холбогдол” сэдвээр мэдээлэл өглөө. | 2024.09<br>2024.11 | 100% |
| **Зорилт 4. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллана”** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | Харъяа дээд шатны албан тушаалтныг төрийн бодлого боловсруулах, асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргахад нь хуульд нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээлэл, мэргэшлийн зөвлөгөөгөөр хангаж ажиллана. | Мэдээллээр хангасан байна. | 100% | Мэдээллээр хангасан байна. | 1.Салбарын хяналтын газрын даргын 2024.01.14-ний өдөр өгсөн үүргийн дагуу Эрүүл мэндийн удирдах ажилтаны зөвлөгөөнд тавих "Салбарын хяналтын газрын 2023 оны эрүүл мэндийн байгууллагуудад хийсэн хяналт шалгалтын товч мэдээлэл, тулгамдсан асуудал" илтгэл бэлдэж хугацанд нь өгсөн.<br>2.Салбарын хяналтын газрын даргын 2024.02.25-ны өдөр өгсөн үүргийн дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд Засгийн газрын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар хэлэлцүүлэгт газрын дарга тавих "Салбарын хяналтын газрын 2023 оны хүнсний эрүүл халдвар, хамгааллын хяналт шалгалтын товч мэдээлэл, тулгамдсан асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга зам" илтгэл бэлдэж өгсөн.<br>3. Төрийн нарийн бичгийн даргад ХХААХҮЯ-ны Салбарын ерөнхий байцаагчийн баталсан "Улсын хэмжээнд мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрүүдэд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" 2023 оны 08-00-02/29 дугаар удирдамжийн хүрээнд ЭМЯ, БОАЖЯ, МЭЕГ, НХХААГ, НМЭГ, НБОГ-ын хамтарсан шалгалтын нэгдсэн дүнгийн танилцуулга, шалгалтаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар товч мэдээлэл бэлтгэж, нэгжийн удирдлагаар дамжуулан мэдээллээр хангасан.<br>4. 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдөр ЭМЯ, аймаг, нийслэлийн 143 улсын байцаагчийг хамруулан цахимаар зохион байгуулсан сургалтад "Хүнсний эрүүл ахуйн хяналтын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөлт, анхаарах асуудал"-аар мэдээлэл бэлтгэж танилцуулга хийсэн.<br>5. ДЭМБ, СХЗГ-ын ХАБҮЛЛ хамтран зохион байгуулсан "Стандарт-Хүнсний аюулгүй байдал" хэлэлцүүлэгт "Салбарын хяналт шалгалтын тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам" илтгэл тавьж, оролцогч талуудын асуултад | 2024.01<br>2024.12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хариулт өгч, 5 хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өглөө. | | |
| 20 | Төрийн үйлчилгээг чирэгдэлгүйгээр чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэх, төрийн үйлчилгээг хүргэхдээ аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх, Архив, бичиг хэргийн хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ. | Хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллана. | Хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн. | Хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн байна. | Тайлант хугацаанд(2024.12.03-ны өдрийн байдлаар) аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн 170 албан бичиг хүлээн авч, 135 хариутай бичгийн 130-г буюу 94.12 хувийг хугацаанд нь шийдвэрлэсэн, 5 албан бичиг шийдвэрлэх шатандаа, хугацаа хоцорсон албан бичиг байхгүй.<br>Иргэдээс ирүүлсэн 4 өргөдөл гомдлын холбогдох хуулийн хугацаанд 100 хувь шийдвэрлэн ажиллалаа. | 2024.01<br>2024.12 | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Худалдааны стандартчилалын хорооны техникийн хорооны бүрэлдэхүүнд ажиллах. | - | - | - | СХЗГ-ын даргын 2024 оны А/17 дугаар тушаалаар Худалдааны стандартчилалын хорооны техникийн хорооны бүрэлдэхүүнд ажиллаж, MNS 5021-1:2024 стандарт батлуулав. | 2024.02<br>2024.05 | 100% |
| 2 | Хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний баг | - | - | - | -ХАБҮЛЛ-ийн захирлын тушаалаар эрсдэлийн үнэлгээний ажлын хэсэгт ажиллаж, АПУ Дэйри ХХК-ийн шинээр бүртгүүлэх хүнсний баяжуулсан 3 нэмэлтийн эрсдэлийн үнэлгээ хийж дүгнэлт, санал өгч ажилласан. | 2024.02<br>2024.12 | 100% |
| | | | | | Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/515 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу ХАБҮЛЛ-ийн даргын тушаалаар томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй хамтран Эсрам Монголиа ХХК-ийн хүсэлтээр Бразил Улсаас импортлох гэж буй “Цайрын глюконат” баяжуулагч бэлдмэлийн Улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбоотойгоор Эрсдэлийн үнэлгээ хийж, бүртгэлтэй холбоотой материалыг судлаж, 6 заалттай зөвлөмж гаргаж хүргүүлсэн. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Стандарт хэмжил зүйн газрын Баталгаажуулалтын | | - | Баталгаажуулалтын гэрчилгээ авсан байна. | Баталгаажуулалтын шинжээчийн эрх олгох сургалтад хамрагдахаар бүртгүүлэх гэсэн боловч тус сургалтад чиглэлийн мэргэжилээр | 2024.04<br>2024.12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шинжээчийн эрх олгох сургалтад хамрагдана. | | | | ажиллаж буй төрийн захиргааны байгууллагад ажиллаж буй улсын байцаагчийг хамруулах шаардлагагүй гэсэн тул Дэлхийн Банкнаас зохион байгуулсан Азийн бүтээмжийн байгууллагын “Хүнсээр дамждаг эмгэг төрүүлэгчийн эрсдэлийн удирдлага” цахим сургалтад хамрагдсан. | | |
| 2 | Мэргэжлийн чиглэлээр сургалтад хамрагдсан байна. | | - | Хамрагдсан сургалтын тоо-2 | -Мянганы сорилтын сангаас зохион байгуулсан Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх гарын авлага боловсруулах зөвлөх үйлчилгээ “Сургагч багш” бэлтгэх сургалт хамрагдаж, сертификат авсан.<br>-Танхимаар болон цахимаар 12 сургалтад хамрагдсан. | 2024.01<br>2024.12 | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:
ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Н.ОДОНЧИМЭГ 2024.12.05